

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.10.14

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Хувьцааны үнэлгээний шинэ дээд амжилт: Ашгийн улирал эхэллээ.
- АНУ-ын 9-р сарын инфляц хүлээлтээс бага зэрэг өндөр гарлаа.
- ХНС-аас одоо хүүг хэвээр үлдээх, эсвэл 0.25%-иар бууруулах хүлээлт давамгайлж байна.
- Хятадын хөрөнгийн зах зээлийн уналтад ирээдүйн хэтийн төлөвийн талаарх хөрөнгө оруулагчдын итгэл багассан нь нөлөөллөө.
- Хятад эдийн засгаа дэмжих арга хэмжээг авч байгаа ч практик үр дүн нь ойрын хугацаанд шууд мэдрэгдэхгүй байх магадлалтай.

2024 он 10-р сарын 14

Dow Jones	42,863.75
S&P 500	5,815.07
Nasdaq	18,342.85
DAX	19,373.93
FTSE 100	8,253.63
S&P/ASX 200	8,252.40
HANG SENG	21,186.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.97%	1.10%	1.29%	11.83%	26.8%	21.9%
S&P 500	0.38%	0.17%	0.84%	21.66%	33.5%	31.0%
Nasdaq	-0.10%	1.04%	0.87%	20.2%	35.0%	24.4%

2024 оны 10 сарын 14-ны 12:00

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.85%	1.32%	0.25%	15.65%	25.6%	25.7%
FTSE 100	-0.17%	-0.18%	-0.16%	6.62%	10.5%	16.7%

2024 оны 10 сарын 14-ны 12:00

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.4%	0.6%	0.9%	9.1%	13.7%	-4.7%
Hang Seng	-0.28%	-0.28%	-0.31%	23.82%	31.4%	-7.5%

2024 оны 10 сарын 14-ны 12:00

ЗӨВЛӨМЖ

3-р улирлын тайлан зарлагдаж эхэллээ:

Тайлангаас өмнө хувьцаа авах нь компани хүлээлтийг давж чадвал ашиг олох боломжтой боловч орлогын хүлээлтэд хүрээгүй тохиолдолд огцом буурах эрсдэлтэй.

Эрсдэлээс зайлсхийх хүсэлтэй хөрөнгө оруулагчид орлогын тайланг хүлээгээд дараа нь худалдан авалт хийх нь илүү аюулгүй сонголт юм.



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хувьцааны үнэлгээний шинэ дээд амжилт: Ашгийн улирал эхэллээ

АНУ-ын хөрөнгийн зах зээлд томоохон индексүүд болох S&P 500, Dow Jones, S&P MidCap 400 бүгд дээд ханшаа шинэчлэн тогтоолоо. Энэ өсөлт нь JPMorgan Chase болон Wells Fargo зэрэг банкнуудын ашгийн тайлан хүлээлтээс дээгүүр гарсан, мөн NVIDIA-ийн хувьцааны өсөлттэй холбоотой. Alphabet (Google)-ийн хувьцаа Хууль зүйн яамнаас тус компанийг хувааж магадгүй гэсэн мэдээлэл гарснаар унасан бол Tesla-ийн роботакси болон робовануудыг хөрөнгө оруулагчид эргэлзээтэй хүлээж авсан нь хувьцаанд нь сөргөөр нөлөөлжээ.

Инфляцын үзүүлэлтүүд ба эдийн засаг

9-р сарын инфляц хүлээлтээс бага зэрэг өндөр гарч, нийт инфляц 0.2%, хүнс болон эрчим хүчийг хассан үндсэн инфляц 0.3%-аар нэмэгджээ. Эрүүл мэндийн үйлчилгээ, тээврийн зардал өссөн бол эрчим хүчний үнэ буурсан нь инфляцын үзүүлэлтийг сааруулсан байна. Инфляцын эдгээр өсөлт нь Холбооны Нөөцийн Сангийн шийдвэрт нөлөөлж, томоохон хүүгийн бууралт хүлээх хүлээлтийг багасгаж байна.

Хүүгийн шийдвэрийн хүлээлт өөрчлөгдөв

Инфляцын мэдээлэл болон ХНС-ийн өмнөх хурлын тэмдэглэлээс харахад, 11-р сард хүүг бага хэмжээгээр бууруулах магадлал өндөр байна. Хэдийгээр өмнө нь 0.5%-ийн хүүгийн бууралт хүлээж байсан бол одоо хүүг хэвээр үлдээх, эсвэл 0.25%-иар бууруулах хүлээлт давамгайлж байна.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хөрөнгийн зах зээл: Итгэл бууралт ба эдийн засгийг сэргээх арга хэмжээний үр дүн
Өнгөрсөн долоо хоногт Шанхайн Composite индекс 3.56%-аар, CSI 300 индекс 3.25%-аар, харин Хонг Конгийн Hang Seng индекс 6.53%-аар уналаа. Хятадын эдийн засгийн нөхцөл байдал болон ирээдүйн хэтийн төлөвийн талаарх хөрөнгө оруулагчдын итгэл багассан нь үүнд нөлөөлсөн гол шалтгаан байв. Энэ нь Хятадын эдийн засгийг дэмжих хүлээлтээс илүүтэйгээр зах зээлд бодит эерэг үр дүн харагдаагүйг илтгэнэ.

Эдийн засгийн сэргэлтийн хүлээлт ба арга хэмжээ

Үндэсний Хөгжил, Шинэчлэлийн хорооноос эдийн засгийн өсөлтийг дэмжих арга хэмжээг түргэтгэхээр мэдэгдсэн нь тодорхой хэмжээний урам зориг өгсөн ч, бодит эдийн засгийн үр дүн хараахан хангалттай биш байна. Хятадын Засгийн газар 2025 онд томоохон хөрөнгө оруулалт, төслүүдийг санхүүжүүлэх урт хугацааны тусгай бонд гаргах, бага орлоготой иргэдэд шууд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй. Гэвч эдгээр арга хэмжээний практик үр дүн нь ойрын хугацаанд шууд мэдрэгдэхгүй байх магадлалтай гэж шинжээчид үзэж байна.

Санхүүгийн зах зээл дэх мөнгөн урсгалын нэмэгдэлт

Хятадын Ардын банк 500 тэрбум юанийн своп солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж, зах зээлд хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээр зорьж буй нь томоохон дэмжлэг болох юм. Энэ хөтөлбөр нь банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад төв банкны үнэт цаасыг барьцаалан зээл авах боломжийг олгож байгаа нь хөрөнгө оруулагчдын идэвхийг дэмжих гол хүчин зүйлсийн нэг болж байна. Гэвч санхүүгийн системд орж буй энэхүү дэмжлэг нь урт хугацааны эдийн засгийн өсөлтийг хангах баталгаа болох эсэх нь эргэлзээтэй байна.

Хэрэглэгчдийн зарцуулалт ба сэргэлт

Хятадын хэрэглэгчдийн баярын үеийн зарцуулалт цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байгаа нь эдийн засагт нэмэлт хүндрэл учруулж байна. Баярын өдрүүдэд зарцуулалт 6.3%-иар нэмэгдсэн нь урьдчилсан таамаглалд хүрээгүй мөн кино театрын борлуулалт 2.1 тэрбум юань болж буурсан нь хэрэглээний эрэлт харьцангуй сул байгааг харуулж байна. Энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжихэд илүү үр дүнтэй бодлого, арга хэмжээ шаардлагатайг илтгэнэ.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

[illegible]